



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 309
танай _____ ны № _____ т

**ХАНГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ТӨМӨРБАТ ТАНАА**

ТАГ-аас танай сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 15,988.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүллээ.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ

006030306



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2023 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.4.2 Авлага	9
3.4.6 Үндсэн хөрөнгө	10
3.4.7 Өр төлбөр	11
3.4.10 Засгийн газрын хувь оролцоо	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.7.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.03.25 № 280

танай _____ ны № _____ т

**ХАНГАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ТӨМӨРБАТ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хангал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг мөрдлөг болгосон байна. ОНХС-гийн төсөл хэрэгжих хугацаанд нийт 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 15 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант 2022 онд 2021 оны V/29 дугаар хуралдаанаар батлагдсан төсвийг 106,027.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 5/29 тоот тогтоолоор 73513.1 мянган төгрөгөөр баталж, төсвийн жилд төсөв 1 удаа тодотгол хийсэн. Төсвийн тодотголыг 2022 оны 07 дугаар

009020281

сарын 01-ны өдрийн 9/02 тоот тогтоолоор 75340.0 мянган төгрөгөөр баталж санхүүжилт олгосон байна. 2022 онд нийт 6 ажилтан ажиллахаар цалин шимтгэлийн санд 46443.6 мянган төгрөг баталж 43466.0 мянган төгрөг зарцуулсан байна. Иргэний танхимын ажилтан нэг орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор хэмнэгдэж, мөн БИНХ-ын дарга нар хуралдааны улирал тутам явуулаагүй үүднээс хуралдаагүй улиралын урамшуулалыг олгоогүй үүднээс хэмнэлт хийсэн байна.

Засаг даргын тамгын газар нь ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 5/29 тоот тогтоолоор 465692,5 мянган төгрөгөөр баталж, төсвийн жилд төсөв 1 удаа тодотгол хийсэн. Төсвийн тодотголыг 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 9/02 тоот тогтоолоор 558731,0 мянган төгрөгөөр баталж санхүүжилт олгосон. 2022 онд нийт 24 ажилтан ажиллахаар цалингийн зардалд 245665,8 мянган төгрөг баталж 245044,5 мянган төгрөг зарцуулсан байна. ХААТ-ын мэргэжилтэн нэг орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор хэмнэгдэж үлдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад тусгай сангийн дансны бичилтийг НББББ-ыг мөрдөөгүй, авлагыг хугацаагаар нь богино болон урт хугацаат авлагаар ангилж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүйгээс бодитой мэдээллээр хэрэглэгчдийг хангаж чадахгүй эрсдэл үүсч байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		967,585.90	386,122.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	223,370.80	85,012.60
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	307,846.30	77,328.40
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	436,368.80	223,781.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,522,581.60	1,364,673.30
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	-	248,610.50
37300	Урт хугацаат зээл		-	248,610.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,522,581.60	1,116,062.80
39200	Биет хөрөнгө		2,457,926.00	1,110,509.40
39300	Биет бус хөрөнгө	13	64,655.60	5,553.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,490,167.50	1,750,795.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		27,383.30	3,041.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	27,383.30	3,041.80
41300	Өглөг	17а, 17б	27,383.30	3,041.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,462,784.20	1,747,753.80
51	Засгийн газрын хувь оролцоо		3,462,784.20	1,747,753.80
51100	Засгийн газрын оруулсан капитал		824,233.00	249,447.10
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		-	249,447.10
51200	Хуримтлагдсан үр дүн		1,563,862.20	1,470,516.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,074,689.00	27,790.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,490,167.50	1,750,795.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,288,292.40	1,599,231.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО		163,236.60	1,135,595.10
110	Орлогын албан татвар		26,647.60	102,248.60
1100	Хувь хүний орлогын албан татвар		26,647.60	102,248.60
113	Хөрөнгийн албан татвар		30,944.30	902,208.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж		105,644.70	131,137.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	317,309.20	195,333.00
120	Нийтлэг татварын бус орлого		299,974.90	195,333.00
121	Хөрөнгийн орлого		17,334.20	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,807,746.60	268,303.50

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,170,644.80	1,233,701.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,170,644.80	1,233,701.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,997,180.90	883,490.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		971,630.90	315,099.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		124,602.60	39,780.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		303,862.00	305,146.80
2104	Хангамж, бараа материалын зардал		48,626.30	31,926.00
2105	Нормативт зардал		199,073.00	468.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,130.30	13,078.90
2107	Томилолт, зочны зардал		3,538.00	7,078.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		9,596.50	1,072.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		332,121.20	169,839.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		173,463.90	350,210.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		117,647.60	365,530.10
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		12,230.00	5,772.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		51,848.80	2,056,027.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		78,028.80	(1,684,725.70)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,161,160.90	1,593,188.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	163,236.60	1,135,595.10
110	Орлогын албан татвар	26,647.60	102,248.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	26,647.60	102,248.60
113	Хөрөнгийн албан татвар	30,944.30	902,208.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,644.70	131,137.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,178.00	49,621.90
1181	Газрын төлбөр	12,667.60	33,286.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	47,799.20	48,229.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	244,902.10	187,698.60
120	Нийтлэг татварын бус орлого	227,567.90	187,698.60
121	Хөрөнгийн орлого	17,334.20	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,753,022.10	269,895.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,859,518.70	1,142,277.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,859,518.70	1,142,277.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,682,928.10	790,302.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	962,923.20	315,099.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,603.30	39,780.90

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	303,464.00	305,146.80
2104	Хангамж, бараа материалын зардал	50,558.70	30,551.40
2105	Нормативт зардал	90,429.80	456.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,482.80	16,945.40
2107	Томилолт, зочны зардал	3,538.00	7,078.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,958.60	1,072.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,969.80	74,172.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	176,590.60	351,975.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	301,642.20	450,911.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	78,978.90	369,785.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,978.90	369,785.00
2200	Дотоод эх үүсвэрээр	78,978.90	369,785.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(78,978.90)	(369,785.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(120,521.80)	(219,484.50)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,521.80	219,484.50
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	102,141.50	(138,358.20)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	121,229.40	223,370.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	223,370.80	85,012.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,384,854.00	3,384,854.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(39,095.50)	(39,095.50)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,345,758.50	3,345,758.50
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	38,996.90	38,996.90
9	Тайлант үеийн үр дүн	78,028.80	78,028.80
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,462,784.20	3,462,784.20
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,462,784.20	3,462,784.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(30,304.60)	(30,304.60)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,432,479.60	3,432,479.60
19	Тайлант үеийн үр дүн	(1,684,725.70)	(1,684,725.70)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,747,753.80	1,747,753.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,613,515.00	1,544,665.87	68,849.13	95.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,195,803.40	1,170,345.56	25,457.84	97.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,592.60	820,134.76	25,457.84	96.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,698.40	315,099.41	3,598.99	98.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,182.60	39,780.94	401.66	99.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304,488.20	302,489.12	1,999.08	99.34
2104	Хангамж, бараа материалын зардал	29,490.50	29,004.70	485.80	98.35
2105	Нормативт зардал	456.00	456.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,986.00	58,970.85	1,015.15	98.31
2107	Томилолт, зочны зардал	7,390.00	7,078.00	312.00	95.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,738.70	1,072.11	666.59	61.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,162.20	66,183.63	16,978.57	79.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	350,210.80	350,210.80	-	100.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	316,918.20	316,918.20	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,292.60	33,292.60	-	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	161,545.90	154,835.80	6,710.10	95.85
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	256,165.70	219,484.51	36,681.19	85.68
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,613,515.00	1,438,567.06	174,947.94	89.16
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,231,041.20	1,277,532.46	(46,491.26)	103.78
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	382,473.80	161,034.60	221,439.20	42.10
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	84	84	84	84
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	41	41	41
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41	41	41	41

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	190,980,128.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,662,065.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,798,659.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,657,714.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,660,080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,702,500.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,778,365.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	863,406.11
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	863,406.11
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	167,318,063.00
2200	Дотоод эх үүсвэрээр	167,318,063.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	189,586,722.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,586,722.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(1,393,406.11)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,393,406.11

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хангал сумын Засаг даргын тамгын газар эрхэм зорилгоо “МУ-ын ЗГ-ын болон аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлжээ. 2022 онд “Эрч хүчтэй, бүтээлч сэтгэлгээтэй шинийг эрэлхийлсэн, чадварлаг эвсэг хам олон хөгжлийн хөтөч уриатай мэдлэг чадварт суурилсан, мэргэшсэн захиргааны байгууллага болох” зорилтыг дэвшүүлэн, үйл ажиллагааны чиглэлээ дараа байдлаар тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (4 удаа)
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд оруулсан нэмэлт өөрчлөлт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт аудитын алба 2022 онд Хангал сумын Засаг даргын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангал сумын Засаг дарга нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,750,795.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,739,371.9 мянган төгрөгөөр буюу 49.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	223,370.80	85,012.60	(138,358.20)
Авлага	307,846.30	77,328.40	(230,517.90)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	248,610.50	248,610.50
Бараа материал	436,368.80	223,781.30	(212,587.50)
Үндсэн хөрөнгө	2,522,581.60	1,116,062.80	(1,406,518.80)
Нийт хөрөнгө	3,490,167.50	1,750,795.60	(1,739,371.90)
Өр төлбөр	27,383.30	3,041.80	(24,341.50)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,462,784.20	1,747,753.80	(1,715,030.40)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,490,167.50	1,750,795.60	(1,739,371.90)

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс нөлөө бүхий буюу материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урт хугацаат хөрөнгө оруулалт, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Материаллаг өөрчлөлт гарсан шалтгаан нь Монгол Улсын засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын өмнөх болон бага дунд боловсролын боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь Боловсролын ерөнхий газрын дарга байхаар батлагдсан, Мөн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсноос нөлөөлсөн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагч аймгийн Засаг дарга байсныг Төсвийн тухай хуулийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн өөрчлөлтөөр хүчингүй болгосонтой холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 223,977.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 85,012.6 мянган төгрөг болж, 138,358.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	221,977.40	85,012.60	(136,964.80)	100.0
Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,393.40	-	(1,393.40)	-
Дүн	223,370.80	85,012.60	(138,358.20)	100.0

Эх сурвалж: Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 19,006.6 мянган төгрөг буюу 22.4 хувийг Байгаль хамгаалах сан, 11,650.5 мянган төгрөг буюу 13.7 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 5,461.2 мянган төгрөг буюу 6.4 хувийг Хоршоо хөгжүүлэх сан, 48,894.5 мянган буюу 57.5 хувийг Орон нутгийн ерөнхий орлого эзэлж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны оны эхний үлдэгдэл 307,846.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 77,328.4 мянган төгрөг болж, 230,517.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Авлагын дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчтай холбогдсон авлага	6,648.70	5,927.20	(721.50)	7.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	54,724.50	-	(54,724.50)	-
Зээлийн хүүгийн авлага	659	669.1	10.10	0.9
Байгууллагаас авах авлага	33,545.50	28,206.00	(5,339.50)	36.5
Хувь хүмүүсээс авах авлага	212,268.60	22,985.50	(189,283.10)	29.7
Хувь хүмүүст олгосон зээл		19,540.60	19,540.60	25.3
Дүн	307,846.30	77,328.40	(230,517.90)	100.0

Эх сурвалж: Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 76,906.8 мянган төгрөг буюу 99.5 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дамжих сан, 403.8 мянган төгрөг буюу 0.5 хувийг Хоршоо хөгжүүлэх сан, 17.7 мянган төгрөг буюу 0.02 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эхний, эцсийн үлдэгдэлгүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 436,368.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 223,781.3 мянган төгрөг болж, 183,721 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Бараа материал дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эм боох материал	20,536.50	-	(20,536.50)	-
Бичиг хэргийн материал	10,211.40	6,500.00	(3,711.40)	2.9
Аж ахуйн материал	83,771.30	33,571.00	(50,200.30)	15.0
Сэлбэг хэрэгсэл	28,152.20	14,058.90	(14,093.30)	6.3
Түлш, шатах тослох материал	3,180.90	369.3	(2,811.60)	0.2

Барилгын засварын материал	5,917.40		(5,917.40)	-
Хүнсний материал	7,194.20		(7,194.20)	-
Бусад хангамжийн материал	260,093.90	159,550.10	(100,543.80)	71.3
Мал амьтад	17,311.00	9,732.00	(7,579.00)	4.3
Дүн	436,368.80	223,781.30	(212,587.50)	100.0

Эх сурвалж: Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 25,470.6 мянган төгрөг буюу 11.4 хувийг Байгаль хамгаалах сан, 194,405.2 мянган төгрөг буюу 86.9 хувийг Засаг даргын тамгын газар, 3,905.5 мянган төгрөг буюу 1.7 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

Засаг даргын тамгын газрын зуслангийн байр барих 3,040.0 мянган төгрөгийн засварын материалыг нөөцөлсөн байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 2,522,581.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,116,262.8 мянган төгрөг болж, 1,406,318.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	4,521,572.80	900,066.20	(3,621,506.60)	80.6
Хуримтлагдсан элэгдэл	(2,587,801.00)	(226,338.00)	2,361,463.00	(20.3)
Авто-тээврийн хэрэгсэл	199,821.80	83,531.80	(116,290.00)	7.5
Хуримтлагдсан элэгдэл	(140,567.20)	(51,528.80)	89,038.40	(4.6)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	326,788.40	267,578.20	(59,210.20)	24.0
Хуримтлагдсан элэгдэл	(121,931.90)	(70,628.40)	51,303.50	(6.3)
Тавилга, аж ахуйн эд хогшил	293,500.00	106,619.30	(186,880.70)	9.6
Хуримтлагдсан элэгдэл	(199,282.80)	(74,908.30)	124,374.50	(6.7)
Зам, гүүрийн байгууламж	1,500.00	-	(1,500.00)	-
Хуримтлагдсан элэгдэл	(900.00)	-	900.00	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	90,000.00	90,000.00	-	8.1
Ном	22,960.40	500.00	(22,460.40)	0.0
Бусад үндсэн хөрөнгө	74,579.10	111,976.80	37,397.70	10.0
Хуримтлагдсан элэгдэл	(22,313.60)	(26,359.30)	(4,045.70)	(2.4)
Програм хангамж	10,856.80	6,556.80	(4,300.00)	0.6
Хуримтлагдсан элэгдэл	(1,439.20)	(1,103.50)	335.70	(0.1)
Бусад биет бус хөрөнгө	55,338.00	300.00	(55,038.00)	0.0
Хуримтлагдсан элэгдэл	(100.00)	(200.00)	(100.00)	(0.0)
Дүн	2,522,581.60	1,116,262.80	(1,406,318.80)	100.0

Эх сурвалж: Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 1,099,745.7 мянган төгрөг буюу 98.5 хувийг ЗДТГ, 16,317.1 мянган төгрөг буюу 1.5 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

Сумын ОНХС-аас хийгдсэн хөрөнгө оруулалтыг сумын Засаг даргын 2022 оны А/46, А/100, А/162, А/198, А/228, А/243, А/244, А/245, А/273 дугаар захирамжуудаар бүртгэлд тусгасан, сумын ИТХ, ЗДТГ, ЭМТ, Соёлын төвийн төсөв захирагч нарын тушаалаар 24,120.4

мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг акталсан, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын хөрөнгүүд тус тус хасагдсанаас буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ИТХ, ЗДТГ өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг акталж данснаас хасах үндэслэл, хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр газар дээр нь шалгуулж, дүгнэлт гаргуулаагүй, мөн эргэлтийн хөрөнгө актлахад дүгнэлт гаргуулаагүй эд хөрөнгийг акталсан байна.

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 27,383.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 3,041.8 мянган төгрөг болж, 24,341.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	8,725.40	-	(8,725.40)	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	18,000.30	1,121.80	(16,878.50)	36.9
Байгууллагад төлөх өглөг	657.6	1,920.00	1,262.40	63.1
Дүн	27,383.30	3,041.80	(24,341.50)	100.00

Эх сурвалж: Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 1,121.8 мянган төгрөг буюу 36.9 хувийг Засаг даргын тамгын газар, 1,920.0 мянган төгрөг буюу 63.1 хувийг Орон нутгийн хөгжлийн сан эзэлж байна.

Оны эцэст үүссэн нь өглөг нь шатахууны үнийн өссөнөөс Засаг даргын тамгын газар НИК-д өглөгтэй, малын тоо толгойн албан татварын орлого дутуу төвлөрснөөс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэгч компанид "АБО" ХХК-д өглөгтэй гарсан байна.

3.4.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 3,462,784.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,747,753.9 мянган төгрөг болж, 1,715,030.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	824,233.00	249,447.10	(574,785.90)	14.3
Хуримтлагдсан үр дүн	1,563,862.20	1,470,516.00	(93,346.20)	84.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,074,689.00	27,790.80	(1,046,898.20)	1.6
Дүн	3,462,784.20	1,747,753.90	(1,715,030.30)	100.00

Эх сурвалж: Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн хувь оролцоо дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 3,617.7 мянган төгрөг буюу 1.5 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, 245,829.4 мянган төгрөг буюу 98.5 хувийг Засаг даргын тамгын газар эзэлж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Татварын орлогыг 1,017.7 сая, татварын бус орлогыг 22.4 сая, тусламжийн орлогыг 93.5 сая, оны эхний үлдэгдлээс 27.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 93.5 сая, нийт 1,133.6 сая төгрөгийн орон нутгийн төсвийн орлогыг бүрлүүлэхээр, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн жилд зарцуулагдах зарлагын дээд хэмжээг 1,133.6 сая төгрөгөөр сумын ИТХ-д өргөн барьж, өөрчлөлтгүй батлуулсан байна.

Өргөн барьсан төсвийг орон нутгийн төсвийн орлогыг сумын ИТХ-ын “Төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны IX/02 дугаар хуралдааны тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг 106.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг шилжүүлгийг 8.2 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Татварын орлогыг 1,017.7 сая, татварын бус орлогыг 22.4 сая, тусламжийн орлогыг 93.5 сая, оны эхний үлдэгдлээс 27.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 93.5 сая, нийт 1,133.6 сая төгрөгийн орон нутгийн төсвийн орлогыг бүрлүүлэхээр, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн жилд зарцуулагдах зарлагын дээд хэмжээг 1,133.6 сая төгрөгөөр сумын ИТХ-д өргөн барьж, өөрчлөлтгүй батлуулсан байна.

Тайлант онд сумын ИТХ-ын “Төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны IX/02 дугаар хуралдааны тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг 106.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг шилжүүлгийг 8.2 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 852,834.0 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа Иргэдийн хурлын дарга 3,780.9 мянга, Засаг дарга 3,601.7 мянга, орон нутгийн өмчийн байр арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,162.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Орон нутгийн төсөвт 317,918.2 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 7. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	75,340.00	71,559.10	3,780.9	95.0
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	558,731.00	555,129.30	3,601.7	99.4
3	Ерөнхий боловсрол	160,422.40	160,418.88	3.5	100.0
4	Соёл урлаг	2,595.00	2,594.92	0.1	100.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	21,837.70	21,785.39	52.3	99.8
6	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	33,907.90	32,801.45	1,106.4	96.7
Нийт дүн		852,834.0	844,289.0	8,545.0	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Сумын Засаг даргын тамгын газар аймгийн Засаг даргын 2022 оны А/354 дугаартай захирамжаар нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг зөрчиж давхардуулсан, Илүү цагийн нэмэгдлийг 12 дугаар сард 4 албан хаагчид 3.2 цагаар хэтрүүлэн олгосон байна.
- Сум хөгжүүлэх сангаас олгосон 1 иргэнтэй холбоотой 15.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй,
- 2022 оны төсөв батлахад ОНХС-ийн хөрөнгөөр "Сумын төвийн камержуулалт засварлах, шинэчлэх" ажилд 31.5 сая, "гэрэлтүүлэг болон гэрэлт гудамж" ажилд 40.0 сая төгрөг тус тус баталсан байсныг төсөвт оруулсан өөрчлөлтөөр сумын төвийн камержуулалт засварлах 11.5 сая, шинэчлэх 20.0 сая, засвар 14.0 сая, засвар 14.0 сая, засвар 12.0 сая төгрөгөөр хуваан босго үнээс хэтрүүлэхгүй баталж шууд гэрээ байгуулсан зөрчил илэрсэн.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 190,980.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт (мянган төгрөг)

№	Эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Шүлхийн шатахууны зардлаас нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлснийг буцаан төлөгдсөн авлага	1,591.5
2	Аймгийн авто замын сангаас ургацын зам засварт	20,000.0
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас эрх шилжүүлж шинэ суурьшлын бүсийн цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд	144,743.4
4	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас морин эргүүлийн урамшуулалд	1,666.0
5	Сумын орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын зардалд	5,000.0
6	Статистикийн хэлтсээс хөдөө аж ахуйн болон хагас жилийн мал тооллого, багийн засаг дарга нарт тооллогын урамшуулалд	1,985.6
7	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас цэвэр орчин цэмцгэр булган аяны зардалд	1,500.0
8	Аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд	5,000.0
9	Усны орлого, усны картын орлого	3,987.7
10	Туслах аж ахуйн орлого /малын ашиг шим/	660.0
11	Түрээсийн орлого	200.0
12	нийгмийн хариуцлагын гэрээнд компаниудаас бэлчээрийн хог хаягдлын төлбөр, ахмадын байрны засварт	4,645.9
Нийт дүн		190,980.1

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хангал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орон нутгийн төсвийн орлого, шилэн дансттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/82 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан нийт орлого ба тусламж санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт батлагдсан орлого ба тусламж санхүүжилт 1,409,441.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,141.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,856.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 116 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 176 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100.0
Нийт дүн	3	-	3	-	100.0

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй хөрөнгөтэй тулгах, хөрөнгийн үлдэгдэлд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,988.7 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 15,988.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд малын тоо, толгойн албан татвар 6,835.9 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд бууны албан татвар 2,857.1 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "өөрийн өмчлөлд байгаа галт зэвсгийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон галт зэвсгийг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах", 7 зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгч албан татварыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор орон нутгийн төсөвт төлнө" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан галт зэвсгийн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллах

3. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд газрын төлбөрийн албан татварыг 6,295.7 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Газрын төлбөрийн орлогыг аймаг, сум, нийслэл, дүүргийн төсөвт оруулна" 10 дугаар зүйлийн 10.4-д "Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина", 10 дугаар зүйлийн 10.5-д "Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллах

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн системд 116 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	-											
ТШЗ	-				-				-			
Дүн	-				-				-			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	4	15.9					4	15.9				
ТШЗ	6	100.5			1	0.7	5	99.8				
Дүн	10	116.4			1	0.7	9	115.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/сая төгрөгөөр/		Зөвлөмж	
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ТТЗ	1						1	-		
ТШЗ	2	-					2	-		
Дүн	3	-					3	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ТТЗ										

ТШЗ								
Дүн								
Нийт дүн	3	-			3	-		

ААБ 5.5: ХАНГАЛ СУМЫН ТТЗ-ЫН АСУУДЛЫН БҮРТЭЛ

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДУТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх
2023.03.25

дд	АГАДУТ-ын дэд ангил	Алдаа, зөрчлийн төвч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөжөөр тооцрх эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харуу	Гаргасан шийдэл
						Стандарт заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Орлого	Тайлант онд малын тоо, толгойн албан татвар 6,835.9 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх". Малын тоо толгойн тухай 4 дүгээр зүйлийн 4.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна", 7 дугаар зүйлийн 7.1 Албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгойг тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэж заасантай нийцэхгүй байна.	6,835,870.00	Материаллаг	Тийм	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх". Галт завсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "өөрийн өмчлөлд байгаа галт завсгийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон галт завсгийг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах", 7 зүйлийн 7.1 Албан татвар төлөгч албан татварыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор орон нутгийн төсөвт төлнө"	Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт оруулах төвлөрүүлсэн төвлөрүүлээгүй эсээл	Албан татварыг бүрэн төвлөрүүлэн ажиллах зөвлөмж өгөх	Зөвлөмж			
2	Орлого	Тайлант онд бууны албан татвар 2857.1 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Галт завсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 "өөрийн өмчлөлд байгаа галт завсгийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон галт завсгийг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах", 7 зүйлийн 7.1 Албан татвар төлөгч албан татварыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор орон нутгийн төсөвт төлнө", гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.	2,857,100.00	Материаллаг	Тийм	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх". Галт завсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "өөрийн өмчлөлд байгаа галт завсгийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон галт завсгийг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах", 7 зүйлийн 7.1 Албан татвар төлөгч албан татварыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор орон нутгийн төсөвт төлнө"	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой	Албан татварыг бүрэн төвлөрүүлэн ажиллах зөвлөмж өгөх	Зөвлөмж			

3	Орлого	Тайланг онд газрын төлбөрийн албан татварыг 6,295.7 мянган төгрөгөөр дагуу бүрдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 "Газрын төлбөрийн орлогыг аймга, сум, нийслэл, дүүргийн төсөвт оруулна" 10 дугаар зүйлийн 10.4 "Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулах, төлөлтөд хяналт тавина", 10 дугаар зүйлийн 10.5 "Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.	6,295,700.00	Материаллаг	Тийм	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 "Газрын төлбөрийн орлогыг аймга, сум, нийслэл, дүүргийн төсөвт оруулна" 10 дугаар зүйлийн 10.4 "Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулах, төлөлтөд хяналт тавина", 10 дугаар зүйлийн 10.5 "Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно"	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой	Албан татварыг бүрэн төвлөрүүлэн ажиллах зөвлөмж өгөх	Зөвлөмж
4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5 Шилэн дансны мэдээлэл	Шилэн дансны нэгдсэн системд 116 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хошуруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Материаллаг	Үгүй	Шилэн дансны тухай хуулийн 4.1.1, 4.1.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5	Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөх	Зөвлөмж
			15,988,670.00						

НИЙТ ДҮН

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Анхан шатанд хянасан

Менежер

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Огноо:

Д.Анхбаяр

Огноо:

Ж.Энхцогдог

Огноо:

Б.Эрдэнэ

Танилцаж зөвшөөрсөн:

Засаг дарга

М.Төмөрбат

Огноо:

СА-ы дарга

Б.Алтанзаяа

Огноо:

6317144798

ГОА0048 3190269

ААБ 5.5: ХАНГАЛ СУМЫН ХХС-ЫН АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДУТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх
2023.02.25

АД	АГАДУТ-ын дэд анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эзэх	Үр өгөөжөөр тооцох эзэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харуу	Гаргасан шийдэл
						Стандарт заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Зардал	Сум хөгжүүлэх сангаас олгосон 1 иргэнтэй холбоотой 15.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зазлийг төлүүлээгүй байна.	15,000,000.0	Материаллаг	Үгүй		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А 7361 дугаар тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг"	Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	Зэвхэлж байгаа зөвлөмж өгөх			Зөвлөмж
Нийт дүн			15,000,000.0									

Бэлтгэсэн:

Ахлах аудитор *Д.Ариунбаяр* Огноо:

Анхан шатанд хянасан: *Ж.Энхтүвшин* Огноо:

Менежер *Б.Эрдэнэ* Огноо:

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор *Б.Эрдэнэ* Огноо:

Тангилцаж зөвшөөрсөн:

Засаг дарга

М.Төмөрбат

Огноо:

СА-ы дарга

Б.Алтанаяа

Огноо:



ААБ 5.5: ХАНГАЛ СУМЫН ОНХС-ЫН АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДУТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх
2023.02.25

ДД	АГАДУТ	АГАДУТ-ын дэд анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эзэх	Үр өгөөжөөр тооцох эзэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харжу	Гаргасан шийдэл
							Стандарт заалт	Хууль тогтоомжийн заалт					
1			<p>2022 оны төсөв батлахад ОНХС-ийн хөрөнгөөр "Сумын төвийн камержуулалт засварлах, шинэчлэх" ажилд 31.5 сая төгрөг, "гэрэлтүүлэг болон гэрэлт гудамж" ажилд 40.0 сая төгрөг баталсан байсныг төсөвт оруулсан өөрчлөлтөөр Сумын төвийн камержуулалт засварлах 11.5, Сумын төвийн камержуулалт шинэчлэх 20.0, Сумын төвийн гэрэлтүүлэг засвар 14.0, Сумын төвийн гэрэлтүүлэг засвар 12.0 сая төгрөгөөр хуваан босо үнээс хэргүүлэхгүй багалж шууд гэрээ байгуулсан зөрчил илэрсэн.</p>	71,500,000.00	Материаллаг	Үгүй	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй төндөр шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн төндөр шалгаруулалт явуулахыг хориглоно".	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрсөн нь төлбөрийн акт тогтоох үндэслэл бүрдээгүй бол	Төндөр шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулахгүй байх зөвлөмж өгөх			Зөвлөмж	
			Нийт дүн	71,500,000.00									

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Д.Аюлбаяр

Огноо:

Анхан шатанд хянасан:

Менеджер

Ж.Энхцолбаяр

Огноо:

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Б.Эрдэнэ

Огноо:

Танилцаж зөвшөөрсөн:

Засаг дарга

М.Төмөрбат

Огноо:

СА-ы дарга

Б.Алтанзаяа

Огноо:

